


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд: +8%, 2019 онд: +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 он 4-р сарын тайландаа тоймлосон байна.

Эх сурвалж: <https://bit.ly/2HJFlip>


ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 3-р сарын байдлаар 25.7 тэрбумын алдагдалтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 12.1 хувиар өсч, зарлага 4.4 хувиар өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 25.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 110.1 хувиар буурсан байна.




Ам.долларын ханш өмнөх сараас 7 төгрөгөөр буурав.

Гуравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 64 төгрөг буюу 2.6 хувиар буурч, өмнөх сартай харьцуулахад 7.5 төгрөг буюу 0.3 хувиар буурч 2395.37 төгрөг болов. 3-р сард гадаад валютын нөөц 2.9 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3 дахин нэмэгдсэн байна.



Инфляцийн түвшин 6.6%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 3-р сард өмнөх сараас 0.9 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн үнэ хамгийн их өсөхөд нөлөөлсөн байна.



Гадаад худалдааны тэнцэл 351.9 сая.ам доллар болов.

2018 оны гуравдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 2612 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 25 хувиар өссөн бол экспорт 14 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 45 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 351.9 сая ам.долларын ашигтай гарлаа.



